



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/65

Есөнбулаг

Газар эзэмших эрхийг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Жүгдэрийн Төгөлдөрийн худалдаа үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 8208001902 нэгж талбарын дугаартай 3002 м2 газрыг “Ундрам-Оюу” ХХК-д, Оросын Төртогтохын орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208002284 нэгж талбарын дугаартай 177 м2 газрыг иргэн Төртогтохын Төрболдод, Нямдаваагийн Бямбажаргалын гэр, орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 8208001470 нэгж талбарын дугаартай 999 м2 газрыг иргэн Дагвадоржийн Эрхэмбаярт, эрх шилжүүлж, эзэмшил газрын хэмжээ, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн иргэний мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны А/289 дүгээр захирамжийн 6 дугаар хавсралт, 2020 оны А/387 дугаар захирамж, 2023 оны А/634 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтын 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

82080010089



Аймгийн Засаг даргын 20 дугаар
02 сарын 17-ны өдрийн 65 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Иргэн, хуулийн этгээдийн овог нэр	Иргэн, хуулийн этгээдийн регистрийн дугаар	Газар эзэмших ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт	Газар эзэмших, ашиглуулах хугацаа
1	Их мянган Төртөгтох Төрболд	ДЮ89021976	Эзэмших	8208002284	177	Жинст баг	Орон сууц (2203)	5
2	Жинчин Дагвадорж Эрхэмбаяр	ДЭ85011013	Эзэмших	8208001470	999	Жаргалант баг	Гэр, орн сууцны хашааны газар (2205)	5

---000---